

Монголын орон нутгийн мэдээ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Таны хөрвөлт

Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Ахлагч Геррит В.Гонг

Оршил

Бидний Аврагч Есүс Христ өөрийн шавь Петрийг “чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:32) хэмээн урьсан. Аврагч Есүс Христ маань биднийг ч бас хөрвүүлэгдээд, ах эгч дүүсээ батжуул хэмээн урьж байна.

Тэнгэрлэг Эцэгийн охид, хөвгүүдийн хувьд бид өсөх мөн өөрчлөгдөх хүч чадвартай билээ. Бид гэрэл болон мэдлэгт өсөн нэмэгдэж чадна. Бид хандлага, чадвар ба зуршлуудаа Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адил болгон өөрчилж чадна. Бид хөрвүүлэгдэж чадна. Бид бусдыг хүчирхэгжүүлж чадна.

Одоо бүгдээрээ гурван асуултын талаар хэлэлцье. Хөрвөлт гэж юу вэ? Судрууд хөрвөлтийг хэрхэн тодорхойлдог вэ? Хөрвөлт ба бусдыг хүчирхэгжүүлэх гэдэг нь хоорондоо ямар холбоотой вэ?

Хөрвөлт гэж юу вэ?

Бид Есүс Христийн сайн мэдээ нь үнэн гэдгийг суралцах үед хөрвөлт ирдэг. Есүс Христийн сайн мэдээний үнэнд суралцах явц нь мэдлэгийг хүлээн авах, хийж гүйцэтгэх мөн өөрчлөгдөх үйл явцыг багтаадаг.

Жишээлбэл, залбирал. Юуны өмнө бид залбирал гэж юу болохыг мэдэж авдаг. Энгийнээр хэлэхэд, залбирал нь талархлаа илэрхийлэхийн тулд, бидэнд эсвэл бидний гэр бүлд хэрэгцээтэй зүйлсийг гуйхын тулд Тэнгэрлэг Эцэгтэй хандан Есүс Христийн нэрээр төгсгөн хэлдэг үгс юм.

Дараа нь бид залбирахыг сурдаг. Өөрсдийн чин сэтгэлийг үзүүлэхийн тулд бид ихэвчлэн өвдөг сөгдөн, гол төлөв нам гүм гэцэрт залбирдаг. Бид ганцаараа, гэр бүлтэйгээ



эсвэл бусадтай хамт хийж болно. Залбирах нь залбирал гэж юу болохыг мэдэхээс илүү зүйл бөгөөд итгэлтэйгээр үйлдэж, гүйцэтгэх зүйл юм.

Бид өглөө, орой бүр залбирахад залбирал нь бидний нэг хэсэг болдог. Бид Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрдэг. Бид илүү итгэлэй болж мөн хайрлахыг сурдаг. Бид гэр бүлээ

**Ахлагч
Геррит В.Гонг**

болон бидний эргэн тойронд байгаа хүмүүсийг адислахыг хүсдэг.

Бас нэг жишээ: аравны нэгийн хууль. Бидэнд байгаа бүхэн Тэнгэрлэг Эцэгээс ирдэг болохыг ойлгож эхэлдэг. Аравны нэг нь итгэлийн зарлиг, салбарын ерөнхийлөгч эсвэл бишопоороо дамжуулан Тэнгэрлэг Эцэгтээ өөрсдийн орлогын аравны нэгийг эргүүлэн өгнө гэсэн үг.

Бид аравны нэгээ бүрэн бөгөөд шударгаар төлж мөн итгэлээ бодит болгосноор үүнийг үйлдэл болгож чаддаг. Энэ нь хялбар зүйл биш. Гэхдээ бид итгэлтэйгээр үйлдсэнээр аравны нэгээ төлөх нь бидний нэг хэсэг болж, аравны нэгийн гэрчлэлийг олж авдаг. Бид Их Эзэний амалтууд болон үнэнийг олж мэддэг. Тэр тэнгэрийн цонхнуудыг нээж, заримдаа хүлээн авах өрөөгүй болтол адислалуудыг цутгадаг (Малахи 3:10; 3 Нифай 24:10). Бид илүү талархалтай, итгэлтэй болдог.

Гурав дахь жишээ: долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, баптисмын ариун гэрээгээ шинэчлэх. Ням гараг бүр ариун ёслолоос хүртэж, өөрсдийн гэрээгээ шинэчлэх нь амьдралын маань нэг хэсэг болж, бид талархлаар дүүрдэг. Бид Аврагчийнхаа үзүүлсэн золиослолыг санан, хүндэтгэдэг. Өөрсдийн үйлдлүүдийг хянаж, нүглүүдээ наманчилснаар бид илүү даруусдаг.

Залбирал, аравны нэг ба долоо хоног бүр ариун ёслолын гэрээгээ шинэчлэх эдгээр гурван жишээ бидэнд хөрвөлт нь мэдлэгийг олж, хийж гүйцэтгэн улмаар өөрчлөгдөх үйл явцыг багтаадаг болохыг сануулдаг.

Судрууд хөрвөлтийг хэрхэн тодорхойлдог вэ?

Хөрвөлт гэдэг нь, зүгээр л итгэхээс эсвэл сайн мэдээний үнэнд үнэмшихээс хамаагүй илүү зүйл болохыг судруудад тодорхойгоор харуулсан байдаг. Хөрвөлт нь бид хэрхэн биеэ авч явах, бид хэн болох

байдалдаа үндсэн өөрчлөлт гаргахыг шаарддаг. Хөрвөлтийн талаар бичсэн судруудыг судлах нь илүү хөрвөгдсөн байхад маань бидэнд тусалдаг.

Библид, Дуулал 19:7-д хэлэхдээ: “Эзэний хууль нь төгс төгөлдөр, сэтгэлийг сэргээдэг, ЭЗЭНий гэрчлэл нь баттай хийгээд гэнэн нэгнийг ухаантай болгодог” гэсэн байдаг.

Матай 18:3-т бидэнд хөрвөлт нь “хүүхдүүдтэй адил болох” гэж хэлдэг.

Мормоны Номын Мозая 3:19-д “хүүхэд шиг болох” нь “хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүх зүйлийг хүлцэхэд бэлэн” болохыг хэлнэ гэсэн. (Матай 18:3 ба Мозая 3:19 дээр бид хөрвөлтийн гол түлхүүр хэсэг нь “болох” гэдгийг дахин харж байна.)

Бид Бурханы хүүхэд шиг Тэнгэр дэх Эцэгтээ нээлтэй, итгэлтэй, найдаж байхыг эрэлхийлдэг үү?

Хиламан 6:3-т, сүмийн хүмүүс хөршүүд нь хөрвүүлэгдэхэд: “тэд нэг нэгэнтэйгээ дотносон нөхөрлөж, мөн нэг нэгэндээ баясан, мөн агуу баяртай” байсныг тодорхойлсон байдаг.

Бид шинээр хөрвөгдөж буй хүмүүсийг уриалгахан, нөхөрсөг дотно, баясалтай, баярлан угтдаг уу?

Алма 23:6 дээр “Их Эзэнд хөрвүүлэгдсэн [хүмүүс], хэзээ ч итгэл алдаагүй нь гарцаагүй.” Эцсээ хүртэл тэвчих хөрвөлт нь “илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн” “мөн тэднээр дамжуулан гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүчний дагуу” “үнэний мэдлэгт авчрагдсан” номлолоос ирдэг.

Бидний хөрвөлт илүү гүн гүнзгий болохын тулд үнэнийг илүү ихээр мэдэж авахыг, илчлэлт ба бошиглолын сүнс, бидний амьдралд байгаа Бурханы хүчийг бид эрэлхийлдэг үү?

3 Нифай 9:20 дээр бид “харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй” байхад хөрвөлт ирдэг гэсэн байдаг. Тэр дараа нь “галаар, Ариун Сүнсээр” мөн “Бурханы Сүнс ба

хүчээр” (3 Нифай 7:21) бидэнд баптисм хүртээж чадна.

Бид Бурханы сайн сайхан, сүр хүчийг мэдэхийн тулд “харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй”, номхон дөлгөөн, Сүнсэнд хүлцэнгүй байх цагийг гаргадаг бил үү? Бид сайн мэдээ нь үнэн гэдгийг мэдэх, аз жаргалтай, баярлан баясах цагийг гаргадаг бил үү?

Судруудаас хөрвөлтийн талаар судалснаар, бид хөрвөгдсөн байдлын зан төлөв болоод адислалуудад суралцдаг.

Хөрвөлт ба бусдыг хүчирхэгжүүлэх гэдэг нь хоорондоо ямар холбоотой вэ?

Эхлээд өөрсдийн хөрвөлт дээр анхаарал хандуулах, дараа нь бидний эргэн тойронд байгаа хүмүүсийг хүчирхэгжүүлэх Аврагчийн урилгын талаар бид олонтаа боддог. Мэдээж, бусдыг өргөхөд туслахын тулд бид сүнслэг байдлын хамгийн өндөрлөгт зогсон байх хэрэгтэй.

Бусдад мэдэх, хийх мөн өөрчлөгдөхөд туслах зуураа бид түүнчлэн өөрсдөө хэрхэн илүү мэдэх, хийх ба өөрчлөгдөх талаар суралцдаг. Заахдаа бид суралцдаг. Суралцахдаа бид заадаг. Суралцагч ба багш бие биенээ ойлгодог, мөн хоёул сэнхэрч мөн хамтдаа баясдаг (С ба Г 50:22).

Магадгүй унших нь бидэнд хэцүү байж болно. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн бидэнтэй хамт уншиж болно. Бид мөн тэд хамтдаа өргөгдөн, хөрвөгддөг.

Магадгүй бид сайн мэдээний нэг зарчмын гэрчлэлтэй байж болно. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн эсвэл найз маань сайн мэдээний бас нэг өөр зарчмын тухай мэддэг байж болно. Хамтдаа бид нэг нэгнээ хөрвүүлэн, хүчирхэгжүүлж чадна.

Бие биендээ туслах арга замуудаар мэдэх, хийх ба өөрчлөгдөх нь бид бүгдийг үнэн Хожмын Үеийн Гэгээнтнүүд болоход маань тусалдаг.

Төгсгөлийн гэрчлэл

Ерөнхий Чуулган дээр Ахлагч Дэвид А.Беднар заримдаа илчлэлтийн сүнс нь харанхуй өрөөнд гэрэл асаахтай адил гэнэт үзүүлэгддэг. Бусад үед илчлэлтийн сүнс нь өглөөний нар мандахтай адил алгуурхан илэрдэг хэмээн заасан (“Илчлэлтийн Сүнс” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, х.87-90).

Үүнтэй адил, заримдаа хөрвөлт маш түргэн, эрчтэй арга замаар мэдрэгдэж болно. Хааяа бид гэнэт “зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлт” ирэхийг мэдэрч болно. Ийм зүйл тохиоход бид “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх” (Мозая 5:2) хүсэлтэй болдог.

Ер нь хөрвөлт маш алгуурхан явагддаг. Ихэвчлэн бид цаг хугацаа өнгөрөх тусам хөрвөлтийг мэдэж, ялгааг нь хардаг. Бид өөрсдийгөө даруусган, “үнэн болоод амьд Бурханд найдлагаа тавьсан” (Алма 5:13) үед зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлт нь аажмаар тохиодог.

Бараг үргэлж, бид Бурханы хайр ба Есүс Христийн сайн мэдээний үнэнийг мэдэрч мөн мэдлэгтэй болох үед, хөрвөлтийн онцгой мөчүүд тохиодог. Энэ нь ерөнхийдөө мөн бид мэдлэг, дуулгавартай байдал ба Христтэй адил зан төлвүүдийг өсгөх тусам эцсээ хүртэл тэвчих амьдралын маань туршид мэдрэгдэх болно.

Биднийг итгэхэд, мэдэхэд, үйлдэхэд цаашид ялангуяа дадал заншил маань болж өөрчлөгдөхөд хөрвөлт гэнэт ба аажим ирдэг гэдгийг би гэрчилж байна.

Хөрвөлтийн тухай судруудаас судлах нь хөрвөлтийг ойлгож, адислалуудыг хүлээн авахад бидэнд тусалж чадна гэдгийг би гэрчилж байна.

Бидний хөрвөлт ба Аврагчдаа өөрсдийгөө зориулах зориулалт маань нэмэгдэх тусам бид бусдыг илүү хүчирхэгжүүлж, мөн хариуд нь тэднээр хүчирхэгжих болно гэдгийг би гэрчилж байна.

Есүс Христийн нэрээр, амен. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

1994 он. улаанбаатар, сэлбэ салбар. /есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм монгол улсын бүртгэлд бүртгэгдэв/.

Манай Ариун Ёслолын үйл ажиллагаанд оролцогчдын тоо нэмэгдэж, мөн шинэ хуулийн зарим нэг зүйл заалт нь Сүмийн цуглаануудыг Төрийн Байгууллагын байранд хийхийг хориглосон тул Салбарын удирдлага цуглаан явуулах шинэ байрны эрэлд дахин гарчээ. Энэ удаад Ариун ёслолын цуглаан өглөө хийгдэхээр өөрчлөгдсөн тул Энхтайван Найрамдлын Ордны захиргаа тухайн цагуудад байр түрээслүүлэх боломжтойг мэдэгджээ.

1994.01.02. Шинэ оны анхны Ариун ёслолын цуглаан болж, өнгөрсөн онд Сүмийн үйл ажиллагаа өгөөмрөөр адислагдсан нь Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христийн ач ивээл байсанд баярласан сэтгэгдлээ илэрхийлж, гишүүд гэрчлэлээ хуваалцжээ. Ахлагч Шмидт, хоёр долоо хоногийн дараа Салбарын Чуулганаар дотоод зохион байгуулалтын өөрчлөлт болох мөн 2 сарын эхний ням гарагийн Ариун ёслолын цуглаан, Энхтайван

Найрамдлын Ордны байранд явагдах болсныг зарлав.

1994.01.09. Нийгмийн Халамжийн Ерөнхийлөгчөөр Даваажаргал /Silvia/, 1-р зөвлөхөд Систэр Донна Бийзли, 2-р зөвлөх – Сансартуяа /Cosmos/, шинэ бичиг хэргийн ажилтангаар Энхжаргал эгч нар дуудагджээ. Ахлагч Вийзли, “Сүмийн дотоод зохион байгуулалт” сэдвээр гишүүдэд дэлгэрэнгүй яриа өгсөн байна.

1994.01 сар. Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд Ерөнхийлөгч Жон Кармак, Нэгдүгээр Зөвлөх Ахлагч Квок Юн Тай, Хоёрдугаар Зөвлөх Давид Е.Соренсон нар ажиллаж байсан ба Салбарын гишүүд, номлогчид шинэ ондоо Азийн Бүсийн Ерөнхийлөгч Стивен Жон Кармак түүний гэргий Систер Кармак нарын айлчлалыг угтах сайхан боломж гарсанд маш баяртай байлаа.

1994.01.15-16. Ерөнхийлөгч Стивен Ж.Кармакийн тэргүүдсэн Улаанбаатар Сэлбэ Салбарын анхны Чуулган чуулж, монгол гишүүд анх удаа Мелкизедек санваар хүртэж, Ахлагчийн албанд Пүрэвсүрэн ах, Бат-Өлзий ах, Энхтүвшин

ах нар томилогдоо. Энхтүвшин Бат-Өлзий нар Салбарын Ерөнхийлөгч Харперын Зөвлөхүүдээр дуудагджээ. Чуулганы хуралд Бүсийн Ерөнхийлөгч Кармак үг хэлж, Систер Кармак, Ахлагч Энхтүвшин, Ахлагч Бат-Өлзий нар гэрчлэл хуваалцсан байна. Чуулганд 125 хүн оролцсон мэдээтэй. Мөн Номлогчдын болон Бүсийн хурал хуралдаж, Ерөнхийлөгч Кармак бүх номлогч нартай ярилцлага хийсэн байна.

“Шашны Шинэ Хууль” Улсын Дээд Шүүхээр хэлэлцүүлэгдэж, Сүмд хамгийн муу нөлөөтэй гэж үзэгдэж байсан гурван заалтыг үндсэн хуулийг зөрчсөн гэж дүгнэн, сүмийн таалалд нийцсэн байна. Хэдийгээр шинэ хуулинд сүмд сөрөг заалтууд үлдсэн ч хуулийн хүрээнд ажиллах боломжтой болжээ.

Ахлагч Бийзлийн хүч чармайлтаар Энхтайван Найрамдлын Ордны захиргаа Цуглаан явуулж болох 300 хүний суудал бүхий заал, туслах бүлгүүдийн ангиуд хичээллэх өрөө, танхмуудыг түрээслэх болж, Ариун ёслолын үйл ажиллагаа явуулах шинэ байрыг үзэж сонирхохоор Азийн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Кармак, Систер Кармак болон ихэнх бүрэн цагийн номлогчид тэнд хүрэлцэн очжээ. Мөн тэндхийн зоогийн газар үдийн хоолонд орцгоосон байна.

1994.02.06. Шинэ байранд болсон Ариун ёслолын цуглааны өдөр гишүүд бас нэг “Анхны” гэсэн зүйлийн гэрч

болсон нь Ахлагч Бат-Өлзий ах шинэ төрсөн бяцхан охиноо адислаж, Мөрөн хэмээн нэрлэжээ. Ирэх пүрэв гарагт нь Ахлагч Энхтүвшин ах өөрийн бага насны хүүхдүүд болох Уянга, Номуунгэрэл хоёртоо адислал өгөх ёслолд номлогчид уригдан оролцжээ.

1994.02.09. Шүүх Яаманд Сүмийг албан ёсоор бүртгүүлж, зөвшөөрөл авах заавар авсан Ахлагч Чарльз Харди гэргий Систер Жин Хардын хамт номлолд үйлчлэхээр ирсэн нь маш сайн хэрэг болов. Учир нь ирэх сарын 1-нд Бийзли ах эгч, мөн 22-нд Харпер ах эгч нарын номлолын хугацаа өндөрлөн, буцах болсон байжээ.

1994.02.27. Салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд өөрчлөлт орж, Ерөнхийлөгч Ричард Г.Харпер болон зөвлөхүүд нь дуудлагаасаа чөлөөлөгдсөн байна. Ахлагч Гари Карлсон шинэ Ерөнхийлөгчөөр, түүний зөвлөхүүдээр Энхтүвшин ах, Бат-Өлзий ах, мөн шинэ Удирдагч Ахлагчаар Чарльз Харди ах нар дуудагджээ.

1994.03.06. Энэ ням гарагт Систер Барбара Л.Карлсон, Систер Донна Бийзлийн оронд Нийгмийн Халамжийн шинэ зөвлөхөөр дуудагдсан байна.

1994.03.13-20. Ариун ёслолын цуглаан дээр Смит ах эгч, Харпер ах эгч нар гэрчлэл хуваалцав.

1994.05.17. Ахлагч Гари Е.Кокс, Систер Кокс болон Ахлагч Ричард Е.Кук, Систер Мэри Нелсон Кук нарын ахмад номлогч гэр бүлийн хосууд Монголын Номлод үйлчлэхээр ирцгээлээ.

1994.06.22. Бүсийн Ерөнхийлөгч Жон Е.Кармак айлчлан ирж, номлогчидтой уулзжээ.

1994.06.26. Улаанбаатар, Сэлбэ салбарын Ерөнхийлөгчийн зөвлөлд өөрчлөлт орж, Ерөнхийлөгч Гари Карлсоны чөлөөлөгдөх хүсэлтийн дагуу чөлөөлөн, өөрийнх нь анхаарал хандуулж байсан гишүүдийн бүртгэлийн системийг компьютерт шивэх, мөн Орчуулгын зөвлөлийн ажлыг хариуцуулжээ. Шинэ Ерөнхийлөгчөөр Ахлагч Гари Е.Кокс, түүний зөвлөхүүдээр Ахлагч Энхтүвшин, Ахлагч Бат-Өлзий нар дуудагдаж, бичиг хэргийн ажилтнаар Пүрэвсүрэн ах, салбарын албан хаагчаар Ариунтулга ах, Нийгмийн Халамжийн Ерөнхийлөгчөөр Даваажаргал эгч нар дуудагджээ.

1994.07 сар. Салбарын ажил хэрэг: Баптисм хүртсэн 102 гишүүдтэй, Ариун ёслолын дундаж ирц 130%, Ням гарагийн хичээл зохион байгуулагдаагүй байсан ч судалгааны ангид Нийгмийн Халамж, Хүүхдийн анги мөн бусад насны ангилалттай бүлгүүдийн хичээл явагдаж байжээ. Америк номлогч нарын удирдлагын

болон багшлах ажлын ачааг хөнгөлөн, дуудлагаас чөлөөлж, зөвлөхөөр дуудан оронд нь монгол ах эгч нарт дуудлага өгч эхэлсэн байна. Бүрэн цагийн номлогчоор дахин зургаан залуу номлогчид үйлчлэхээр ирсэн байна.

1994.08 сар. Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд Ерөнхийлөгч Жон Кармак, Нэгдүгээр зөвлөх Квок Юн Тай, Хоёрдугаар зөвлөх Жон Х.Гроверг нар ажиллаж байлаа.

Бригам Янгийн Хавай дахь салбар Их сургууль нь монгол гишүүдийн сургаалийн болон ахуйн амьдралд их чухал ач холбогдол бүхий үүрэг гүйцэтгэсэн болно. Эхний удаа Салбарын 7 гишүүн, удаад нь 1995 оны өвлийн семестрт 15, мөн нэмэгдсээр 20 монгол оюутанд суралцахын зэрэгцээ ажил хийх программ танилцуулснаар өөрсдийгөө санхүүжүүлэх чадвартай болгох үйл ажиллагаа үргэлжилсээр байжээ.

1994.10.24. Монгол Улсад шинээр үүсч байгаа шашны байгууллагыг монгол хүн удирдах тухай Монгол Улсын Үндсэн Хуулинд өөрчлөлт орсноор Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн мөрийн хөтөлбөрийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд Энхтүвшин ах танилцуулсан байна. Түүний эхлэн байгуулагдаж байгаа шинэ хэн Сүмийн үйл ажиллагаанд

оруулсан хувь нэмэрт талархаж байна.

1994.10.27. Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн дагуу Улсын Бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн байна.

1994.11 сар. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс Ахлагч Квок Юн Тай айлчлан ирж, номлогч нартай уулзан номлолын заавар өгөх, Ариун ёслолын цуглааныг тэргүүлэн удирдаж, сүнслэг яриа, гэрчлэлээрээ гишүүдэд хайраа үзүүлжээ. Ариун ёслолын талх усыг адислаж түгээсэн сүмийн албан хаагч болон багш нарын зохистой хувцас /цагаан цамц, зангиа/ түүнд онцгой сэтгэгдэл төрүүлж айлчлалаа дуустал дурьдсан байна. Гишүүдийн тоо нэмэгдэх тусам сорилт ирсээр, Энхтайван Найрамдлын Ордны захиргаа 1994 оны 2 дугаар сард хийсэн нэг жилийн түрээсийн гэрээг дахин сунгах боломжгүйг мэдэгджээ. Бас манай Цуглааны ажиллагаанд хүүхэд ирэхэд дургүйцэн, “хүмүүс холхилдож байна” гэсэн шалтаг гаргаж байжээ. Эцэст нь хэлэлцэлд хүрч, шинэ гэрээг байгуулжээ. Энхтайван Найрамдлын Ордон нь Сүмийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөхцөл байдал нь тохиромжгүй газар байсан гэдэг. ■

Хамтдаа сүнслэг байдлыг суралцах нь

Сүмийн удирдлага гишүүдийг бие биендээ тусалж, цаг заваа зөв зохистой өнгөрөөх үйл ажиллагаануудыг урамшуулан дэмждэг билээ. Үүний хүрээнд Сонгино байрны 18-30 насны институтын ангийнхан мөн Сэлбэ тойргийн ах эгч нар оны бяцхан цасны баярыг зохион байгууллаа. Энэ бүхэн гишүүдийн сүнслэг байдлыг улам өсгөж, бие биенээсээ суралцаж, сорилтын дэлхий дээрх саад бэрхшээлийг хамтдаа туулж, бие биенээ хүчирхэгжүүлэх эрч хүчийг өгдөг. ■

*Сонгино
байрны
институтын
ангийн залуус*





Сэлбэ тойргийнхон

Сэлбэ тойргийн Нийгмийн Халамжийн эгч нар



Бас нэгэн баярт чуулган

Нийгмийн Халамжийн байгууллага үүсч хөгжсөний 170 жилийн ойн баярыг тохиолдуулан Улаанбаатар Баруун Гадасны Нийгмийн Халамжийн чуулган 2012 оны 03-р сарын 17-нд Баянзүрх байранд болж, энэхүү чуулганд 6 тойргийн 230 гаруй эгч нар оролцлоо.

Чуулганы гол зорилго бидний амьдарч буй сорилтын дэлхийд Есүс Христийн сайн мэдээний зарчмуудад түшиглэн зорилготой амьдарч, өдөр бүр тулгарах асуудал бэрхшээлүүдэд хандах хандлагаа эерэгээр өөрчлөн, ямар нэгэн хариу нэхэлгүйгээр бусдад хайр энэрэл, үйлчлэл үзүүлэхэд хэрхэн тэдгээр асуудлууд эерэгээр шийдэгдэж, Түүний сайн мэдээний амлалтын дагуу аз жаргал, амар амгалан авчирч болдгийг эгч нартайгаа хуваалцах явдал байсан бөгөөд энэхүү зорилгодоо ч амжилттай хүрсэн юм.

Энэ удаагийн чуулганы онцлог нь эгч нар хамтдаа цуглан баяраа тэмдэглэж, сүмийн удирдагч нараас суралцахаас гадна, өөрсдөө энэхүү чуулганы арга хэмжээг зохион

Эгч нарт жүжигчилсэн тоглолт олон зүйлсийг бодогдуулал зогсохгүй мөн маш их таалагдлаа





Даалгавар 4:
Та энэ танхимд нүүсэн 1
зүйлийг дараахь
удирдамжийн дагуу
олно үү.

байгуулахад удирдлагуудтайгаа хамтран гар бие оролцон үйлчилж, Нийгмийн Халамжийн зорилго болон дуудлагаа биелүүлсэн явдал байлаа. Сонгино болон Сансар тойргийн эгч нар өдөр тутам тулгарах асуудлууддаа хэрхэн эерэгээр хандаж болохыг жүжигчилсэн тоглолтоор үзүүлсэн нь олон эгч нарын асуултуудынх нь хариулт болоод зогсохгүй, чуулганаас олсон мэдлэг нь амьдралаа сайн мэдээгээр удирдан чиглүүлэх улам их эрч хүч, урам зоригийг хайрласан талаар эгч нар хуваалцаж байв. Хан – Уул тойргийн эгч нар чуулганы өмнө танхмыг чимэглэж, энэхүү үйлчлэлээс тэд олон зүйл сурснаа хуваалцсан бол Залуу насанд хүрэгчдийн хорооны эгч нар сандал засах зэргээр өөр бусад олон эгч сайн дураараа энэхүү чуулганыг амжилттай явуулахад тусалсан нь Улаанбаатар Баруун Гадасны эгч нар сайн мэдээнд хэрхэн нэгдмэл байгааг харуулж чадсан сайхан үйл явдал болсон юм. ■

**Танхмыг
чимэглэсэн
эгч нартаа
баярлалаа**

**Эгч нар маш
анхааралтай-
гаар сонсож
байлаа**



Гэгээнтнүүдийн дуу хоолой

Багануур салбарын залуус гэрчлэлээ хуваалцаж байна.

Энхжин: Мормоны Номноос бошиглогчид ямар их дуулгавартай байсныг, тэдний энэ дуулгавартай байдлын хариуд асар их адислалууд ирж байсныг суралцсан.

Гантогтох: Мормоны Номон дахь Лемен Лемеул нар шиг тийм муухай, зөрүүд ааштай байх нь муу харин Нифай шиг байхыг хүссэн. Бурханыг дуулгавартай дагавал луужин зөв зүгт заадаг шиг зөвийг олно гэдгийг би мэдэж сурсан.

Уянга: Мормоны Ном үнэхээр гайхалтай. Энэ номноос судалж, сурснаар гэрэл гэгээг өөрсдөөсөө цацруулж чадна. Бошиглогчдын дуулгавартай байдал намайг гайхшруулдаг.

Болор: Залуучуудын чуулганаар олон зүйлийг сурч мэддэг. Би их бүрэг, нийгмийн идэвх султай хүүхэд байсан. Сүмийн гишүүн болсноос хойш энэ зан маань өөрчлөгдөж, улсын олон тэмцээнд оролцон түрүүлсэн. Сүм намайг нээж өгсөн. Хүн эгэл чанаруудаа харж, удирдагчдын үгийг дагаснаар зөв замыг олж болохыг би сурсан. Бид салбараараа Мормоны Ном уншиж байгаа. Бүгд хамтдаа байдагт би их талархдаг.

Нарангарав: Сүмийн гишүүн болоод би маш их өөрчлөгдсөн. Мормоны Ном уншсанаар гэр бүл болон хувь хүмүүсийг адисладаг.

Буянхишиг: Би 2011 оны 6 сард баптисм хүртсэн шинэ гишүүн. Надад энэ сүмийн гишүүн байх таалагддаг. ■